

ХЯТАДЫН ЭРТНИЙ НИЙСЛЭЛ – СИ-АНЬ ХОТ

Л.БЭГЗЖАВ*

Хятадын баруун хойт хэсэгт Шэньси мужийн төв хэсэгт, Шар мөрний цутгалан Вэйхэ голын дагуу зүүнээс баруун тийш сунаж тогтсон нарийн хөндийг Гуаньжуны тал гэдэг. Энэ талын төв хэсэгт Хятадын соёл иргэншлийн эртний голомт Си-ань хот байдаг. 9900 гаруй хав.дөр.км газар нутагтай, 6 сая гаруй хүн амтай Си-ань бол Хятадын эртний долоон том нийслэлийн нэг.

1100 гаруй жилийн түүхэндээ Хятадын 13 улсын нийслэл байсан Си-ань хот Египетийн Каир, Грекийн Афин, Италийн Римийн хамт дэлхийд нэртэй эртний нийслэл хот юм.

Си-ань хотыг мэдвэл Хятадыг ойлгож мэднэ гэсэн яриа байдаг нь оргүй үг биш юм. Эрт цагт Си-анийг Чань Ан гэдэг байжээ. Энэ нэр өнө удаан засаглал, амар тайвны билэгдэл болж байв. 800 мянган жилийн тэртээгээс энэ газарт анхны хүмүүс суурьшиж байсны ул мөрийг 1963 онд археологчид олсон юм.

МЭӨ XI зуунаас МЭ 771 он хүртэл оршин байсан Баруун Жоу улсын үеэс сайхан байгальтай, халуун рашаан ихтэй, газарзүйн таатай байрлалтай энэ нутагт Хятадын хичнээн хаан, хаан ширээнд заларсныг төсөөлөхөд хэцүү билээ.

Баруун Хань улсын (МЭӨ 206-МЭ 8 он) Уди хааны үед Дундад, Баруун Ази, Римийн

эзэнт улс хүртэл “Алдарт торгоны зам”-ыг эндээс тавьсан юм.

Хятадын феодализмын алтан үе болох Тан улсын (МЭ 618-907) үед Си-ань хот онцгой хөгжиж, өнөөгийн Си-аниас 5 дахин том нутагтай дэлхийн хөгжилтэй том хот, олон улсын харилцааны чухал зангилаа газар болж байлаа.

Эртний Египетийг фараонууд шиг Хятадын хаад өөртөө аварга том бунхан бариулдаг уламжлалтай билээ.

Си-аний ойролцоо 70 гаруй хаадын бунхан байдгийн заримыг нь газар доорх ордон гэж нэрлэдэг. 1974 онд газар хагалж байсан нэгэн тариачин эр Линьтун хошуунд Хятадын феодлын анхны эзэнт гүрэн Хань улсын (МЭӨ 221-206 он) эзэн хаан Цинь Шихуандийн бунханг олсноор бүх дэлхийг шуугиулсан юм.

2000 гаруй жилийн тэртээх эртний цэрэг, морьдын хөшөө 6000 гаруйг олж, музей байгуулснаар “дэлхийн найм дахь гайхамшиг” олны анхаарлыг улам бүр татах болжээ. Жуулчлалын дахин давтагдашгүй 8 бүсэд хуваагддаг Си-аний ойролцоо 2 сая гаруй түүх дурсгалын үзмэр байдгаас Си-анийг “Хятадын түүхийн музей” гэж нэрлэдэг юм.

*Л.Бэгзжав. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Хятад судлалын секторын эрхлэгч, доктор (Ph.D), профессор